

**БҮГД НАЙРАМДАХ ХЯТАД АРД УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР, МОНГОЛ
УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР, ОРОСЫН ХОЛБООНЫ УЛСЫН ЗАСГИЙН
ГАЗАР ХООРОНДЫН ГУРВАН УЛСЫН ХИЛИЙН ЗҮҮН
УУЛЗВАРЫН ЦЭГИЙН ТУХАЙ ТОДОРХОЙЛОЛТ-ПРОТОКОЛ**

Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар, Монгол Улсын Засгийн газар, Оросын Холбооны Улсын Засгийн газар (цаашид Хэлэлцэн тохирогч Талууд гэж нэрлэх),

Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар, Монгол Улсын Засгийн газар, Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын гурван улсын улсын хилийн уулзваруудын цэгийг тодорхойлох тухай 1994 оны 1 дүгээр сарын 27-ны өдрийн Хэлэлцээрийн дагуу хятад - монгол - оросын хамтарсан ажлын хэсэг гурван улсын улсын хилийн Зүүн уулзварын цэгийг байршилг тодорхойлж, хилийн "Тарваган Дах" тэмдэг босгосныг харгалзан,

дор дурдсан зүйлийг хэлэлцэн тохиров.

Нэгдүгээр зүйл

Хятад улс, Монгол улс, Орос улсын улсын хилийн Зүүн уулзварын цэг нь 645.0 тоот бүхий өндөрлөг дээрх Тарваган Дахын /Газрбаганьдаху, Тарбаган-Дах / овооны төвд оршино.

Энэ цэг нь хятад-монголын хилийн шугам дээрх хилийн 639 дүгээр тэмдгээс зүүн хойдын хойд зүгт 8,7 метрт, монгол-оросын хилийн шугам дээрх хилийн 964 дүгээр тэмдгээс зүүн өмнийн өмнө зүгт 759,7 метрт, хятад-оросын хилийн шугам дээрх хилийн 1 дүгээр тэмдгээс баруун хойд зүгт 147,8 метрт байрлана.

Уг цэгийн солбицлыг газар дээр нь багажаар 1 метрээс хэтрэхгүй нарийвчлалтайгаар хэмжин тодорхойлж, түүний өндрийг ЗСБНХУ-д 1981 онд хэвлэсэн 1:100 000-ны масштабтай газрын зургаас авав. Солбиллыг 1942 оны, өндрийг Балтийн тогтолцоонд тус тус харуулав.

Зүүн уулзварын цэгийн солбицол нь:

-газарзүйн:

$B = 49^{\circ}50'42''$,3

/хойд өргөргөгийн/

$L = 116^{\circ}42'46''$,8

/зүүн уртрагийн/

-тэгш өнцөгт:

$X = 5\,523\,751.6$

$Y = 20\,479\,357.0$

Өндөр нь 645.0 болно.

Хоёрдугаар зүйл

Гурван талын хамтарсан ажлын хэсэг гурван улсын улсын хилийн Зүүн уулзварын цэгт, Тарваган Дахын /Газрбаганьдаху, Тарбаган-Дах/ овооны төвийн дээр, "Тарваган Дах" нэртэй, "0" дугаартай хилийн тэмдэг босгов.

Хилийн "Тарваган Дах" тэмдэг нь гурван талт боржин багана, металл тулгуур хэсэг болон төмөрбетон сууриас бүрдэнэ.

Хилийн тэмдгийн гадаад хэлбэр маяг, хэмжээ бүхий зураг, мөн уг хилийн тэмдгийн Протокол нь энэхүү Тодорхойлолт-протоколын хавсралт болно.

Гуравдугаар зүйл

Энэхүү Тодорхойлолт - протоколын хавсралт болох 1:10 000-ны масштабтай "Бүгд Найрамдах Хятад Ард Улс, Монгол Улс, Оросын Холбооны Улсын улсын хилийн Зүүн уулзварын цэгийн орчмын газрын зураг"-т Бүгд Найрамдах Хятад Ард Улс, Монгол Улс, Оросын Холбооны Улсын улсын хилийн Зүүн уулзварын цэгийн байрштыг улаан тойргоор, Зүүн уулзварын орчимд гурван улсын улсын хилийг улаан шугамаар тус тус харуулав.

Дөрөвдүгээр зүйл

Гурван улсын улсын хилийн Зүүн уулзварын цэгээс улсуудын хил дараах чиглэлээр явна:

- Хятад улс, Монгол улсын хоорондын улсын хил нь шулуун шугамаар баруун өмнийн өмнө зүг чиглэн хятад-монголын улсын хилийн шугам дээрх хилийн 639 дүгээр тэмдэг хүртэл явна.

- Монгол улс, Орос улсын хоорондын улсын хил нь шулуун шугамаар баруун хойдын хойд зүг чиглэн монгол-оросын улсын хилийн шугам дээрх хилийн 964 дүгээр тэмдэг хүртэл явна.

- Хятад улс, Орос улсын хоорондын улсын хил нь шулуун шугамаар зүүн өмнө зүг чиглэн хятад-оросын улсын хилийн шугам дээрх хилийн 1 дүгээр тэмдэг хүртэл явна.

Тавдугаар зүйл

1. Хэлэлцэн тохирогч Талууд хилийн "Тарваган Дах" тэмдгийг шилжүүлэн зөөх, эвдэх буюу алга болгох явдал гаргахгүй байхад чиглэгдсэн шаардлагатай арга хэмжээг авна.

Аль нэг Тал нь дангаараа уг тэмдгийн байршил, хэлбэр, хэмжээг өөрчлөх буюу хилийн уулзварын цэгт хилийн шинэ тэмдэг босгох эрхгүй.

2. Хятадын Тал хилийн "Тарваган Дах" тэмдгийн баганыг арчлан хамгаалах, засварлах үүрэг хүлээнэ. Монголын болон Оросын Тал уг хилийн тэмдгийн суурь, металл тулгуурыг арчлан хамгаалах, засварлах үүрэг хүлээнэ.

3. Хэлэлцэн тохирогч Талуудын аль нэг нь хилийн "Тарваган Дах" тэмдгийг шилжүүлсэн, эвдсэн, алга болгосныг илрүүлсэн тохиолдолд нөгөө хоёр Талдаа даруй мэдэгдэнэ. Хилийн энэхүү тэмдгийг уг тэмдгийн Протоколд заасан хэмжигдэхүүний дагуу хариуцагч Талууд сэргээн босгох, засварлах ажлыг гүйцэтгэхдээ бүх Талын төлөөлөгчдийг байлцуулж гүйцэтгэнэ.

4. Хэлэлцэн тохирогч Талууд шаардлагатай үед хилийн "Тарваган Дах" тэмдэгт хамтарсан шалгалт хийж болно.

5. Хэлэлцэн тохирогч Талууд хилийн "Тарваган Дах" тэмдэгт шалгалт хийсэн, засварласан, сэргээн босгосон дүнгийн тухай хамтарсан протокол үйлдэж, Хэлэлцэн тохирогч Талуудын төлөөлөгчид гарын үсэг зурсны дараа энэхүү Тодорхойлолт-протоколд хавсаргаж байна.

Зургадугаар зүйл

Хэлэлцэн тохирогч Талууд, өөрсдийн хууль тогтоомжийн дагуу баталсан тухай мэдэгдсэн бичгийг харилцан солилцсон сүүлчийн өдрөөс эхлэн энэхүү Тодорхойлолт-протокол хүчин төгөлдөр болно.

Энэхүү Тодорхойлолт-протоколыг 1996 оны 6 дугаар сарын 24-ний өдөр Бээжин хотноо хятад, монгол, орос хэлээр тус бүр гурван эх хувь үйлдсэн бөгөөд эх бичвэрүүд нь адил хүчинтэй байна.

БҮГД НАЙРАМДАХ
ХЯТАД АРД УЛСЫН
ЗАСГИЙН ГАЗРЫН
ӨМНӨӨС

МОНГОЛ УЛСЫН
ЗАСГИЙН ГАЗРЫН
ӨМНӨӨС

ОРОСЫН ХОЛБООНЫ
УЛСЫН ЗАСГИЙН
ГАЗРЫН ӨМНӨӨС

张德广

